



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/53

Шивээговь сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол хэлний тухай хуулийн 17.1.3, "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III"-ийн 5.1.1, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, 2.1.6 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Үндэсний бичиг, соёлын өдрийг тохиолдуулан Шивээговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, бага ангийг сурагчид болон төрийн албан хаагчид, иргэдийн дунд 2023 оны 05 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Үндэсний бичгийн олимпиадын арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, арга хэмжээний зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээний төсвийн дагуу 1,500,000 /нэг сая таван зуун мянган/ төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхн шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ





2023 оны 05 -р сарын 04 -ны өдрийн  
A/53 Захирамжийн хавсралт-1

**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР” ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Бүх нийтийн үндэсний бичгээрээ түргэн унших, алдаагүй зөв бичих сонирхол хэрэгцээнд тулгуурлаж, үндэсний бичгийн түргэн унших, зөв бичих чадварыг нэмэгдүүлэх

**Хамрах хүрээ:** Шивээговь сумын төрийн албан байгууллага болон албан хаагчид /Байгууллага бүрийн нийт ажилтан, албан хаагчид/

**Хугацаа:** 5 сарын 3-нд

- Илчлэг шивээ ОНӨҮГ- 16 цагт
- ЗДТГ- 17 цагт
- ИТХ-17цагт
- ШГС ЭМТ- 17 цагт
- 3 дугаар цэцэрлэг- 18 цаг
- ШГС ЕБС – 19 цагт

**Хаана:** Шивээговь сумын ЕБС, “Эх хэлний танхим”-д

**Зохион байгуулалт:**


“Үндэсний хөтөлбөр-3” хэрэгжүүлэх ажлын хүрээнд унших чадвар, бичих чадвар, хэлзүйн агуулгаар материал боловсруулж, олимпиад зохион байгуулна.

**Шагнал:**

3. Байгууллагаас эхний /1 байр эзэлнэ/  
✓ Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
4. Төрийн албан хаагчид /3 байр/  
1 байр: Мөнгөн шагнал, дурсгалын зүйл  
2 байр: Мөнгөн шагнал, дурсгалын зүйл  
3 байр: Мөнгөн шагнал, дурсгалын зүйл

**БОЛОВСРУУЛСАН:  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЕБС  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БАГ**

Сумын Засаг даргын  
2023 оны 05-р сарын 04-ны өдрийн  
Захирамжийн хавсралт-1  
1/53



**ҮНДЭСНИЙ БИЧИГ, СОЁЛЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛЖ  
БУЙ**

**“ЭХ ХЭЛ – ЭРДМИЙН ТҮЛХҮҮР” ОЛИМПИАДЫН ТӨСӨВ**

20023.4.11

	Нэр	Зориулалт	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
<b>ЕБС-ийн бага, дунд ахлах анги</b>					
1	I байр мөнгөн шагнал	Бага, дунд, ахлах анги	3	130000	390000
2	II байр мөнгөн шагнал	Бага, дунд анги	3	110000	330000
3	III байр мөнгөн шагнал	Бага, дунд анги	2	90000	180000
<b>Төрийн албан хаагчид</b>					
7	Иш хөрөг А4	ТАХ	3	18000	54000
8	Мөнгөн шагнал				
	1 байр	ТАХ	100000	100000	100000
	2 байр	ТАХ	80000	80000	80000
	3 байр	ТАХ	50000	50000	50000
<b>Иргэд</b>					
9	Иш хөрөг А4	Иргэн	2	18000	36000
10	Мөнгөн шагнал				
	1 байр	Иргэн	50000	50000	50000
	2 байр	Иргэн	30000	30000	30000
<b>Төрийн албан байгууллага</b>					
11	Өргөмжлөл	ТАБ	1	30000	30000
12	Хүний нэрийн толь		1	50000	50000
<b>Бичиг хэргийн зардал</b>					
13	Бичгийн цаас	Олимпиад материал	3	20000	60000
14	Өргөмжлөлийн цаас	Бүгд	1	20000	20000
<b>Нийт</b>					<b>1500000</b>

**Төсөв гаргасан:**

Нийгмийн бодлогын мэргэжилтэн:

Б.Алтансүх